



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/651

Алтай хот

Бодлогын баримт бичиг боловсруулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10, 8.2, 9 дүгээр зүйлийн 9.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

- Д.Батбилэг -аймгийн Засаг даргын зөвлөх
- аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- П.Золжаргал -Есөнбулаг сумын иргэдийн Хурлын дарга
- Д.Чинзориг -Есөнбулаг сумын Засаг дарга
- Г.Лхагважаргал-аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
- Д.Алтанзагас -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Архивын тасгийн дарга
- Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2.


- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Засаг даргын бодлого, шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хууль эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн биелэлт, шүүх, хуулийн байгууллагын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого, зарлага хариуцсан ахлах мэргэжилтэн
- Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, спортын бодлого, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хариуцсан мэргэжилтэн
- Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны бодлого хариуцсан мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчин, геологи, уул уурхай, аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- НҮБ-ын Хүүхдийн сангийн "Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн зөвлөх
- Эрүүл мэндийн газрын дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

3.

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Мал эмнэлгийн газрын дарга
- Биеийн тамир, спортын газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Онцгой байдлын газрын дарга
- Орон нутгийн өмчийн газрын дарга
- Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга
- Сум дундын ойн ангийн дарга
- Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал

2.Бодлогын баримт бичгүүдийн төслийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөртэй уялдуулан 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНГБААТАР